

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Ариг гал” ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх

Гүйцэтгэх захирлын тайлан.

Илтгэгч нь: Гүйцэтгэх захирал Х.Хания (15 мин)

2. “Ариг гал” ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулах

Илтгэгч нь: ТУЗ-ийн аудитын хорооны дарга Б.Аюуш (10 мин)

3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох талаар нэр дэвшигчдийг танилцуулах.ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг

ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн Э.Бямбажав (15 мин)

4 Компанийн 2021 оны ашгаас Ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлэх

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (10 мин)

5. Компанийн удирдлагын 2022 оны зардлын төсөвийг танилцуулах,

ТУЗД-ын ажлын албаны СТА-ны дарга Ч.Энхцэцэг (10 мин)

6. Хурлаар хэлэлцэх асуудлаар санал шүүмжлэл асуулт хариулт явуулах

Хурлын дарга Д.Мөнхбат (хүн тус бүрт мин-аар хурлаас тогтоох)

7. Хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар санал

хураалт явуулах, дүнг ХЭХ-д танилцуулах

Тооллогын комиссын дарга Д.Мөнхбаатар

8. Хурлаас гарсан шийдвэрийг хэлэлцүүлж батлуулах

Хурлын дарга Д.Мөнхбат (цаг тогтоохгүй)

Хурлыг хуралдуулах нийт хугацааг цагаар ХЭХ-аас тогтоох

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2022 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД

Гүйцэтгэх захирал Х.Ханиягийн тайлан:

Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

“Ариг гал” ХК–ийн хувьцаа эзэмшигчидэд, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс өнгөрсөн хурлаас хойш хийсэн ажил, тавьсан зорилгоо хэрхэн хэрэгжүүлснээ тайлагнаж байна.

Тайлангийн хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурлаас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан явууллаа. Үүнд:

Нэг. Борлуулалтын орлогын талаар

“Ариг гал” группийн харъяа компаниудын дүнгээр 27,3 тэрбум төгрөгийн орлоготой, 716,3 сая төгрөгийн ашигтай ажиллаж, үйлдвэрлэлд 649,1 сая төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байрыг бий болгож, Улсын төсөвт 2,2 тэрбум гаруй төгрөгийн татвар шимтгэлийн орлого төвлөрүүлж ажиллалаа.

Манай компани нь тайлангийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлэн тавьсан 1,090.0 сая.төгрөгийн орлого төвлөрүүлэх зорилтоо 2 дахин давуулан биелүүлж, 2,273.2 сая.төгрөгийн орлоготой ажиллаа, Түрээсийн орлого 248,8 сая төгрөгт хүрч төлөвлөсөнөөс 37,8 % буурсан ч, өмнөх оноос 5,1 %-иар өссөн. Харин ногдол ашгийн орлого төлөвлөсөнөөс 40%-иар өссөн биелэлттэй байна. 2021 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Ариг гал ХК-ийн 2020, 2021 оны орлого, үр дүнгийн харьцуулалт /мян.төг/

дд	Үзүүлэлт	2020 оны		2021 оны		2022 оны төлөвлөгөө
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	Борлуулалтын орлого	1,715,000.0	1,927,911.1	1,090,000.0	2,808,540.9	1,546,000.0
2	Үүнээс:түрээсийн	400,000.0	236,144.1	400,000.0	248,807.5	400,000.0
3	Бусдаас авсан ноогдол ашиг	1,300,000.0	1,663,755.0	675,000.0	1,132,852.2	546,000.0
4	Бусад орлого	15,000.0	28,011.7	15,000.0	1,426,881.2	600,000.0
5	Нийт зардал	1,411,717.0	1,514,331.5	982,010.0	2,108,509.7	1,261,410.0
6	Нийт ашиг	303,283.0	413,579.6	107,990.0	700,031.2	284,590.0
7	Ашгаас санхүүжих зардал	15,000.0	75,348.0	15,000.0	3,734.0	15,000.0
8	ААНОАТ	23,380.9			142,688.1	60,000.0
9	Цэвэр ашиг	264,902.1	338,231.6	92,990.0	553,609.1	209,590.0

Хоёр.Санхүүгийн байдлын талаар

2021 оны тайлан балансаар үйл ажиллагааны зардлаа 26,3 сая төгрөгөөр буюу 3,2%-иар бууруулсан байгаа. Ашиглалтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 105.9 сая төгрөгөөр буурсан ч цалин, зээлийн хүүгийн зардал 84,8 сая төгрөгөөр өссөн байна.

Санхүүгийн тайлан балансаар өнгөрсөн 2021 онд төлөвлөсөн зардлаас 18,8%-иар бууруулсан. Орлогоосоо 1,1 тэрбум төгрөг-ийг ноолуурын үйлдвэрлэлд түүхий эдийн санхүүжилт хийж, энэ хэмжээний банкны зээл авахгүйгээр зохицуулсан. Балансын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хураангуй балансаас харуулбал:

Ариг гал ХК-ийн 2021 оны жилийн эцсийн хураангуй БАЛАНС /мян.төг/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл		Өсөлт бууралт	
	2020.12.31	2021.12.31	дүнгээр	хувиар
А.ХӨРӨНГӨ				
1. Эргэлтийн хөрөнгийн дүн	36,948,844.2	37,902,020.7	953,176.50	2.6
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	141,512.4	45,083.3	(96,429.10)	-68.1
Авлага	36,776,299.0	37,825,904.6	1,049,605.60	2.9
Үндсэн туслах материал	31,032.8	31,032.8	-	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			-	
2. Биет хөрөнгийн дүн	2,774,413.0	2,646,278.7	(128,134.30)	-4.6
3. Биет бус хөрөнгийн дүн	528,962.2	527,326.4	-	0.0
4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	18,230,411.2	18,230,411.2	-	0.0
Нийт хөрөнгийн дүн	58,482,630.6	59,306,037.0	825,042.2	1.4
Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧД- ӨМЧ			-	
1. Өр төлбөрийн дүн			-	
Богино хугацаат өр төлбөр	49,484,363.8	49,756,467.6	272,103.80	0.5
Урт хугацаат өр төлбөр	566,219.4	563,913.0	(2,306.40)	-0.4
Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр			-	
2. Хувьцааны дүн	347,932.0	347,932.0	-	0.0
Халаасны хувьцааны дүн	(9,142.8)	(9,142.8)	-	0.0
3. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,598,730.6	6,598,730.6	-	0.0
4. Хуримтлагдсан ашиг	1,159,097.3	1,159,097.3	-	0.0
Тайлант үеийн ашиг	335,430.3	553,609.0	218,178.70	65.0
5. Эзэмшигчийн өмчийн дүн	8,432,047.4	8,650,226.1	218,178.70	2.6
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	58,482,630.6	58,970,606.7	487,976.1	0.8

Орлогын тайлан /мян.төг-өөр/

Санхүүгийн үзүүлэлт	Орлогын тайлан		Өсөлт бууралт	
	2020.12.31	2021.12.31	дүнгээр	хувиар
Борлуулалт	235,635.4	248,807.5	13,172.10	5.6
Борлуулалтын хөнгөлөлт урамшуулал			-	
Цэвэр борлуулалт	235,635.4	248,807.5	13,172.10	5.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-	
Ашиг	235,635.4	248,807.5	13,172.10	5.6
Үйл ажиллагааны зардал	823,477.8	797,139.3	(26,338.50)	-3.2
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	926,073.9	1,244,629.0	318,555.10	34.4
Үүнд: Ноогдол ашгийн орлого	1,663,755.2	1,132,852.2	(530,903.00)	-31.9
Хүү, хөрөнгө оруулалтын орлого	28,011.7	1,426,881.3	1,398,869.60	
Валютын ханшийн ашиг алдагдал	(579,640.9)	(535,314.5)	44,326.40	-7.6
Үйл ажиллагааны бус зардал	(186,052.1)	(779,790.0)	(593,737.90)	0.0
Татварын өмнөх ашиг	338,231.5	696,297.2	358,065.70	105.9
Татвар	2,801.2	142,688.1	139,886.90	0.0
Цэвэр ашиг	335,430.3	553,609.1	218,178.8	105.9

Компани нь тайлант хугацаанд улсын төсөвт 256,2 сая төгрөгийн татвар шимтгэл төлсөн.

Үүнд: НӨАТатварт -19,9 сая төгрөг,
 НДШимтгэлд -62,04 сая.төгрөг,
 Газрын төлбөрт -107,3 сая төгрөг,
 ҮХХТатварт -43,0 сая төгрөг,
 ХАОАТатварт -24,7 сая төгрөг тус тус төлсөн.

Гурав. 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн

зорилтын биелэлтийн талаар

Ариг гал ХК нь **үйлдвэрлэлийн** компаниудын үйл ажиллагааг дэмжих, ажиллах нөхцлийг сайжруулах, хэвийн, жигд, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр ажиллаж группийн хэмжээгээр дараахь ажлуудыг гүйцэтгэлээ.

1. Үйлдвэрлэлийн барилгын Худалдааны төвийн хуучин заал, принтийн цех, ноолуурын агуулах, химийн бодис хадгалах байр, ширмэлийн цехийн хуучин оёхын өрөө, АА-ны болон эмчийн өрөө зэрэг 6200 м2 талбайд засвар, үйлчилгээ хийж, 106,0 сая.төгрөгний хөрөнгө зарцууллаа.
2. Зөөлөн оёдлын үйлдвэрлэлд 10 шулуун оёдлын хагас автомат машиныг 20,8 сая.төг-өөр худалдан авч суурилуулснаар пальто пиджакны үйлдвэрлэл өмнөх оноос 10,5%-иар нэмэгдэх боломжтой болсон.
3. Бүх үйлдвэрлэлийн компаниудын машин тоног төхөөржмийн их, дунд засварын ажилд зориулж дотоодоос болон импортоор авах сэлбэгт 189,0 сая.төг-ийн, засвар үйлчилгээг хийлгэж хүлээн авсан.
4. Компанийн цахилгаан эрчим хүчний хангалтын найдвартай ажиллагааг хангах зорилгоор олон жил ашиглаагүй байсан 10 квт-ын 2 секцийг ажилд оруулж ХУД-ийн Өмнөдийн станцаас 1200м 240*3 хос кабелийн шугамыг гадны мэргэжлийн компаниар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авч, 168,0 сая.төг-ийг зарцуулж, 5 жилийн баталгаа гаргуулаа.
5. Сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж гадаадаас ирэх 7G-ийн экспортын захиалгыг нэмж авах зорилгоор Японы “Шима”-гийн бүрэн автомат 4ш машиныг 163,5 сая.төг-өөр худалдан авч, суурилуулж, ажиллуулснаар сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадал 15%-иар нэмэгдлээ.
6. Кашмер холдинг ХХК нь бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газраас Ямааны ноолуур, тэмээний ноосон утас үйлдвэрлэх, сүлжмэл, нэхмэл, оёмол, ширмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэх стандартын шаардлагыг хангаж, чанарын менежментийг нэвтрүүлж “Чанарын менежментийн тогтолцоо “ISO9001:2015” стандартыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, чанарын баталгаажуулалтын гэрчилгээгээ авснаар манай ноолууран бүтээгдэхүүн Олон улсын зах зээлд чанартай бренд болон үнэлэгдэх үндэс суурь тавигдлаа.

Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэц нь ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээр ажиллаж байгаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер холдинг ХХК -иуд үйл ажиллагаагаа явуулж байна. .

Кашмер холдинг ХХК-ийн харъяанд түүний охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд үйл ажиллагаа явуулж байна.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь Ажлын албаараа дамжуулан бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого, удирдлагаар хангаж ажиллаж байгаа.

ТУЗ-ийн даргын АА нь ТУЗ-д туслах чиг үүрэгтэй бөгөөд группийн харъяа компаниудыг ТУЗ-өөс явуулж байгаа удирдлага, менежментийн бодлогыг хэрэгжүүлэх, харъяа компаниудын ажлыг дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах асуудлыг ТУЗ-ийн даргад тавьж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулах зорилгоор шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, тус шалгуур үзүүлэлтээр компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулан ажилласан.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь

Одоогийн байдлаар компанийн хувьцааг 7371 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр

19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байна. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшиж байна.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон МХБ,СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн байгаа.

Компани өөрийн хувьцааны 3.2%-ийг халаасласан байна. Бусад 44.4%-ийн хувьцаа нь 7367 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа болно.

Зургаа. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.

Тус компани нь дэлхий дахинд тархсан цар тахлын улмаасүйл ажиллагааг хумагдаж, жилээс жилд ашиг орлого буурсаар байгаа ч хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээсэн үүрэгтээ хүндэтгэлтэй хандсаар ирсэн. Тухайлбал: 2019 онд нэгж хувьцаанд 38,92 төгрөг хуваарилж, ногдол ашигт 135,0 сая.төг-ийг, 2020 онд нэгж хувьцаанд 38,93 төгрөг хуваарилж, ногдол ашигт 135,4 сая.төг-ийг хуваарилан хувьцаа эзэмшигчдэд тараасан байгаа.

Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 18-ны өдрийн 12/21 тоот тогтоолоор 2021 оны ногдол ашигт нэгж хувьцаанд 39,90 төгрөг хуваарилж, 138,8 сая.төгийг ногдол ашигт зарцуулахаар шийдвэрлэснийг өнөөдрийн ХЭХ-д танилцуулж байна. Уг ногдол ашгийг 2022 оны 6 сараас хэтрүүлэхгүйгээр нийтэд зарлан тараах болно.

Долоо. Цаашид хийх ажил

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж, эргэлтийн хөрөнгийн зээл авахад нь дэмжлэг үзүүлж, Монголын ноолууран брендийг бий болгоход хувь нэмрээ оруулах.
2. Ашиглаж чадахгүй, байхгүй, ашиглалтаас гарсан зарим газрыг зарж борлуулан банкны зээл, хүүг төлж барагдуулснаар цаашид банкинд хүү төлөх гэх мэт зардлыг багасгаж ашиг орлогоо нэмэгдүүлэх.
3. Хонины ноосон утас хийхэд хэрэглэж байсан хуучин тоног төхөөрөмж, сэлбэгийг зах зээлийн үнээр борлуулж, барилга байшин, газраа чөлөөлж, үйлдвэрлэлийн байр талбайг томруулж, ажиллах нөхцлийг сайжруулж, түрээсийн орлогоо нэмэгдүүлэх.

Хүндэтгэсэн: Гүйцэтгэх захирал

Х.Хания